# “ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Дугаар 15 “ГТХЗНТ” УТҮГ

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулж удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталсан ГТХЗНТ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалыг баримтлав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд “ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, сайдын албан даалгаврууд, сайдын шуурхай хуралдаан, захирлын тушаал, нэгжийн гүйцэтгэлийн болон нэгжүүдийн сарын ажлын төлөвлөгөө, захирлын шуурхай зөвлөгөөн, нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт, шилэн дансны хөтлөлт, туслах чанараар баталсан төлөвлөгөө гэсэн хяналт тавьж биелэлтийг гаргах шаардлага бүхий **12** үзүүлэлтээр **108** баримт бичигт туссан **789** арга хэмжээг хамруулж дүгнэсэн.

## Гурав. Үнэлгээ

3.1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 38 арга хэмжээний хэрэгжилтийг доорх хүснэгтээр үзүүлэв.

| Нэгжийн нэр | Нийт арга хэмжээ | Үүнээс | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| ЗСХ | 8 | 4 | - | 2 | 1 | - | 1 | - | 74.56 |
| ТНУАСХ | 18 | 10 | 1 | 4 | 1 | - | 1 | 1 | 83.53 |
| ГХБАБМХ | 10 | 7 | - | 1 | 2 | - | - | - | 87.00 |
| Хамтран хэрэгжүүлэх | 2 | - | - | 1 | 1 | - | - | - | 65.45 |
| | **38** | **21** | **1** | **8** | **5** | **-** | **2** | **1** | **81.55** |

Төсвийн ерөнхийлөн захирагч хянаж, төсвийн шууд захирагч баталсан “ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023.09.21-ний өдрийн байдлаар 100%-ийн биелэлттэй 21, 90%-ийн биелэлттэй 1, 70%-ийн хэрэгжилттэй 8, 50%-ийн хэрэгжилттэй 5, тасарсан 2, хугацаа болоогүй 1 арга хэмжээтэй, хэрэгжилт дундажаар 81.55%-тай байна.

Биелэлт хангалтгүй үнэлэгдсэн 7 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

“Үр дүнгүй” буюу 0%-ийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:

| № | Арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтыг автоматжуулах туршилт судалгаа хийх | ***Хагас жил, жилийн эцсийн байдлаар:***<br>Суурь бүтэц эзэмшигчийн сэлгээний 2 зүтгүүрт 3-аас дээш сарын хугацаатай FMB640 маркийн төхөөрөмж суурилуулж туршилт зохион байгуулсан байна.<br>Туршилтын үр дүн, дүгнэлтийг төмөр замын байгууллага, ЗТХЯ-нд танилцуулсан байна. | “Ти Ти Түүлс” ХХК-иас FMB640 маркийн GPS навигацийн систем ашиглан тээврийн хэрэгсэлд хяналт тавих системийн шийдэл бүхий бүтээгдэхүүнийг 2023.03.03-ны өдөр танилцуулж, сэлгээний зүтгүүрт GPS системийг суурилуулж өгөгдөл цуглуулах туршилт хийх, дүн шинжилгээ, тайлангийн боловсруулалт хийхэд тус систем нь бүрэн боломжтой талаар санал илэрхийлсэн. Суурь бүтэц эзэмшигч байгууллагын сэлгээний зүтгүүрт суурилуулж бодит туршилт хийх өртөөний байршил, зүтгүүрийг тодорхойлох зорилгоор 2023.06.12-ны өдрийн 14:00 цагт “МТЗ” ТӨХК-д галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтыг автоматжуулах системийн судалгааны ажлыг танилцуулсан. “УБТЗ” ХНН-ийн Зүтгүүрийн аж ахуйн албаны орлогч дарга Д.Хорлоо болон бусад албан хаагчдад 2023.08.28-ны өдөр “Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтыг автоматжуулах туршилт судалгаа”-ны ажлыг танилцуулж хамтарсан туршилт хийх санал дэвшүүлсэн. “УБТЗ” ХНН талаас судалгаанд хамтран ажиллах, цаашлаад хятадын системийг нэвтрүүлэн туршиж үзэх арга замыг тодорхойлох тухай сонирхолтой байгаа талаар дурдан, 2023 оноос “Гайхам” ХХК-тай хамтран сэлгээний зүтгүүрт GPS систем, түлш мэдрэгч системүүдийг байршуулан туршиж эхэлсэн тухай мэдэгдсэн. Тус туршилтын өгөгдлийг манай төвтэй хуваалцаж өгөгдөлд хамтран дүн шинжилгээ хийж, сэлгээний ажлын өнөөгийн нөхцөл байдлыг илүү бодитоор судлахад хамтран ажиллахаар зөвшилцсөн. |
| 2 | ЗТХЯ, “ГТХЗНТ” УТҮГ, УБТЗ ХНН-ийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлын явцад хяналт тавьж ажиллах | ***I-II улирал:***<br>Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан байна. Барилгын ажлын төлөвлөгөө батлагдсан байна.<br>***I-II улирал:***<br>Орон сууцжуулах болон орон сууц захиалан бариулах нэмэлт гэрээ байгуулсан байна. | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2023.04.14-ний өдөр барилгын талбайд гүйцэтгэгч компанийн захирал, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал, орон сууц захиалагч нартай уулзалт зохион байгуулж, гүйцэтгэгч компанийн захирал цаашид барилгын ажлыг үргэлжлүүлэх санхүүгийн боломжгүйг мэдэгдсэн. 2023.04.20-ны 164 дугаартай албан бичгээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн. Орон сууцны барилгын зураг төслийг зохиогч “Эдшил” ХХК-иар барилгын баганад хүчитгэл хийх зураг боловсруулж ирүүлсэн. Барилгын захиалагчийн хяналтын зөвлөл БУА-ыг үргэлжлүүлэх гүйцэтгэгчийн саналыг хүлээн авч байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байсан “Ди Ди Эм Ти” ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэсэн. Гүйцэтгэгч компанийг Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэст гомдол гаргаж шалгуулж байна. Орон сууцны хяналтын зөвлөл хуралдаж нийт захиалагчдаас 2 заалтад санал авахаар шийдвэрлэсний дагуу төвийн ажилтнууд саналаа хяналтын зөвлөлд хүргүүлсэн. |

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50%-иар үнэлэгдсэн 5 арга хэмжээ:

| № | Арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийг үргэлжүүлэх | ***III улирал:***<br>Барилга угсралтын ажлын даалгавар боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын эх загвар зургийг Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар 2023.04.14-ний өдөр баталсан. Гадна шугам сүлжээний зураг төсвийг барилгын зураг төслийн ажил гүйцэтгэгчээр, авто зам болон гэрэлтүүлгийн зураг төсвийг “ЗТХТ” ТӨҮГ-аар магадлуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ЗТХ-ийн сайдад 2023.04.28-ны өдрийн 183 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Барилгын зураг төсөв хийгдсэн бөгөөд барилга угсралтын ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 12 сард багтаан зохион байгуулахаар төлөвлөж байна. Зураг төсөв хийгдсэн тул дахин ажлын даалгавар боловсруулагдахгүй. Барилгын зураг төсөв боловсруулах ажлыг “Эм Эс Эл” ХХК-иар гүйцэтгүүлж магадлалаар баталгаажуулан хүлээн авсан. Улмаар 2023 оны 3 улиралд багтаан барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж барилгын суурийн ажлыг 10 сард эхлүүлэхээр төлөвлөж байсан. Гэвч зохиогчийн хяналтын зөвлөхийн зүгээс 10 сард барилгын ажил эхлүүлэх нь технологийн горим алдагдах эрсдэлтэй гэж зөвлөсөн тул угсралтын гүйцэтгэгчийг 12 сард багтаан сонгох, барилгын ажлыг 2024 оны 4 сард эхлүүлэхээр бэлтгэх тухайг КОЙКА тал мэдэгдсэн. |
| 2 | Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн боловсруулах | ***III улирал:***<br>Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийн дагуу төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна. | Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн боловсруулж Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу төмөр замын байгууллагаас санал авахаар “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК, “ТТЗ” ХХК, “МТЛ” ХХК-д 2023.04.05-ны 133 дугаартай албан бичгийг хүргүүлснээс “УБТЗ” ХНН-ийн Мэдээллийн технологийн алба, Статистик бүртгэлийн төв, Тээвэр зохион байгуулалтын албанаас 2023.04.26-ны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 22/32, “МТЛ” ХХК-иас 2023.05.22-ны 23/367, “ТТЗ” ХХК-иас 2023.05.22-ны 2/889 дугаартай албан бичгээр санал ирүүлсэн. Журмын төслийн хэлэлцүүлгийг 2023.07.25-ны өдөр зохион байгуулж ЗТХЯ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК, “БТЕГ” ХХК, “Монголиан транс ложистик” ХХК-ийн нийт 15 төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлгээр журмын төсөлд ирүүлсэн саналыг хэлэлцэж, журмын хавсралтаар баталсан маягтуудыг шинэчлэн боловсруулж Зам тээврийн салбарын нэгдсэн платформд маягтуудыг үүсгэх, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийх, уялдуулах үйл ажиллагааг гүйцэтгэж байна. |
| 3 | КОЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн төмөр замын аюулгүй байдлын нэгдсэн системтэй холбогдох стандартын судалгаа хийх | ***IV улирал:***<br>БНСУ-ын галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой багц стандартыг судалж төвийн үйл ажиллагаанд тохирох стандартыг сонгож 1-2 стандартыг орчуулсан байна. | БНСУ-ын төслийн менежментийн зөвлөх (PMC) багтай хийсэн яриа хэлэлцээ, цахим уулзалт, харилцсан албан бичигт БНСУ-ын галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой холбогдох стандартыг судлах, албан хэрэгцээнд орчуулах асуудлаар хүсэлт тавьсан. БНСУ-ын галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой KRS PW 0071-22R Тогтмол гүйдлийн төмөр замын дүүжин тусгаарлагч (шаазан), KRS PW 0070-22R DC төмөр замын тулгуур тусгаарлагч (шаазан), KRS PW 0069-22R DC төмөр замын урт хугацааны тусгаарлагч (шаазан), KRS PW 0062-22R Өндөр хурдны трамвай замын материалд зориулсан хөнгөн цагаан ба хөнгөн цагааны хайлш цутгамал, KRS PW 0061-22R Өндөр хурдны трамвай шугамын материалд зориулсан зэс-хөнгөн цагаан хайлш цутгамал, KRS PW 0057-22R Өндөр хурдны төмөр замын T-sx-ийн дүүжин тусгаарлагч, KRS PW 0056-22R өндөр хурдны төмөр замын тусгаарлагч тусгаарлагч NSP-40, KRS PW 0055-22R өндөр хурдны галт тэрэгний холын зайн хаалт T-mx, Төмөр замын дизайны стандарт (архитектур) 2019, Төмөр замын дизайны стандартууд (Метроны эрчим хүчний хувилбар) 2021, Төмөр замын зураг төслийн стандартууд (холбогдсон тээврийн хэрэгсэл) 2019, Төмөр замын тээвэрт ашиглагдах 9 төрлийн хөдлөх бүрэлдэхүүнийг батлах, тавигдах ерөнхий шаардлага 2015, Төмөр замын туннелийн зураг төсөл зохиох стандарт KDS) 13 стандартыг судалсан. Төмөр замын тээвэрт ашиглагдах хөдлөх бүрэлдэхүүний ерөнхий шаардлага стандартыг орчуулж боловсруулсан. Төмөр замын туннелийн зураг төсөл зохиох стандарт стандартыг орчуулж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт MNS 6630:2016 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах | ***I-II улирал:***<br>Стандартыг шинэчлэн боловсруулсан байна. Холбогдох байгууллагаас санал авсан байна.<br>***IV улирал:***<br>ТЗДАУЗТС-ын Техникийн хороогоор хэлэлцүүлсэн байна. | Стандартын төсөлд “ТТЗ” ХХК, “УБТЗ” ХНН, “МТЛ” ХХК, ТЗДС 2023.05.12-ны 1/800, 2023.06.08-ны 05/1979 тоотоор санал ирүүлснийг стандартад тусгасан. “ГТХЗНТ” УТҮГ, ТЗДС, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “МТЛ” ХХК, “ТТЗ” ХХК-ийн төлөөллөөс бүрдсэн хөдлөх бүрэлдэхүүн дугаарлалт. 1, 2, 3, 4-р хэсэг Төмөр замын зорчигчийн вагоны дугаарлалтад тавих шаардлага, Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага, Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага, Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-1,2,3,4:2016 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг төвийн захирлын 2023.05.18-ны өдрийн А/27 дугаар тушаалаар байгуулж ажлын хэсэг 2023.06.07, 2023.06.15, 2023.06.30-ны өдөр хуралдсан. Хөдлөх бүрэлдэхүүн дугаарлалт. 1-р хэсэг стандартын төслийг эцэслэн боловсруулсан. 2, 3, 4-р хэсэг стандартын төслийн хэлэлцүүлгийг 2023.09.19-ний өдөр зохион байгуулсан. |
| 5 | Төвийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хөтлөх | ***II улирал:***<br>Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж баталсан байна.<br>***II-III улирал:***<br>Архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлэх, тооллого зохион байгуулж дүн мэдээ гаргасан байна. | Төвийн албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, стандартын дагуу бүрдүүлж хөтөлсөн. 2023.09.12-ны өдрийн байдлаар ирсэн албан бичиг 485, явсан албан бичиг 394, тушаал 90, өргөдөл 16, нийт 985 баримт бичиг бүртгэгдсэн. Нийт ирсэн бичгийн 321 буюу 66 хувь нь хариутай бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт 96 хувь. Архивын ерөнхий газраас төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлаар 2023.03.01-ний өдөр мэргэжил, арга зүйн зөвлөгөө авсан. Төвийн захирлын 2023.03.01-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж хөтлөх хэргийн болон устгах хэргийн нэрийн жагсаалтыг баталсан.<br>Төвийн захирлын 2023.03.31-ний өдрийн Б/14 дүгээр тушаалаар албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтнийг АЕГ-аас зохион байгуулж буй “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжил дээшлүүлэх” сургалтад 2023.04.03-05.05-ны өдрийг дуустал хамруулсан. Архивын ерөнхий газрын мэргэжилтэн н.Өнөртуяа 2023.06.26-ны өдөр “Баримт бичгийг стандартын дагуу зохион байгуулахад бүрдүүлэхэд тавигдах шаардлага” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулж нийт ажилтанд хамрагдсан. |

3.2 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

| Нийт заалт | Үнээс (хувиар) | | | | | | Хэрэгжилтийн дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | - | - | - | - | 1 | - | 30.0 |

"Хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

I. 3.6.1.Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ Богдхан төмөр зам болон баруун босоо чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгана. 3.3. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл

Зорилтот түвшин: 2023 он: Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь

Биелэлт:

1.Нийслэлийн Засаг даргын захирамж 2022.01.11-ний өдрийн А/15 дугаар захирамжаар Баянгол дүүрэг 20-р хорооны нутаг дэвсгэрт 4000м.кв талбай бүхий газар эзэмшүүлэх эрхийн улсын бүртгэлийн Э-2205002528 дугаартай гэрчилгээг гаргуулсан.

2.2022.03.04-ний өдрийн Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжлийн зөвлөлийн хурлаар Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулсан.

3.2022.08.12-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер зарласан.

4.Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын эх загвар зургийг Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар 2023.04.14-ний өдөр баталсан. Гадна шугам сүлжээний зураг төсвийг барилгын зураг төслийн ажил гүйцэтгэгчээр, авто зам болон гэрэлтүүлгийн зураг төсвийг "ЗТХТ" ТӨҮГ-аар магадлуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ЗТХ-ийн сайдад 2023.04.28-ны өдрийн 183 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Барилгын зураг төсөв хийгдсэн бөгөөд барилга угсралтын ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 12 сард багтаан зохион байгуулахаар төлөвлөж байна. Зураг төсөв хийгдсэн тул дахин ажлын даалгавар боловсруулагдахгүй. Барилгын зураг төсөв боловсруулах ажлыг "Эм Эс Эл" ХХК-иар гүйцэтгүүлж магадлалаар баталгаажуулан хүлээн авсан. Улмаар 2023 оны 3 улиралд багтаан барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж барилгын суурийн ажлыг 10 сард эхлүүлэхээр төлөвлөж байсан. Гэвч зохиогчийн хяналтын зөвлөхийн зүгээс 10 сард барилгын ажил эхлүүлэх нь технологийн горим алдагдах эрсдэлтэй гэж зөвлөсөн тул угсралтын гүйцэтгэгчийг 12 сард багтаан сонгох, барилгын ажлыг 2024 оны 4 сард эхлүүлэхээр бэлтгэх тухайг КОЙКА тал мэдэгдсэн.

3.3. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт:

| Тушаалын тоо | Нийт заалт | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| 11 | 22 | 14 | 4 | 3 | - | 1 | - | 84.38 |

"Хэрэгжилт хангалтгүй" 30%-ийн хэрэгжилттэй 3 заалт:

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Хэрэгжүүлэх заалт | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | ЗТХ-ийн сайдын 2021.02.09-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 19 дүгээр тушаал | 1.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний | МУЗГҮАХХАХТөлөвлөгөөний 3.6.1.3.3.Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийн хүрээнд Төслийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн судалгааг 2020.09.11-30-ны хугацаанд гүйцэтгэсэн. СЯ, ЗТХЯ-ны ТНБД, Койкагийн монгол дахь суурин төлөөлөгч нар Төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрийн протоколд 2021.08.16-ны өдөр гарын |

| | | | |
|---|---|---|---|
| | | төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, зам, тээврийн салбарт 2020-2024 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах 2. батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүр тайлагнаж ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга нарт даалгасугай. | үсэг зурж баталгаажуулсан. Төсөл хэрэгжих газрыг НЗД-ын 2022.01.11-ний өдрийн А/15 дугаар захирамжаар шийдвэрлүүлсэн. БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 4000м2 газрыг "ГТХЗНТ" УТҮГ-т 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх шийдвэр гарч төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 0000034438 дугаартай гэрчилгээ олгогдож, НГЗБА-тай иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх 01107-2022/00057 дугаартай гэрээг 2022.06.08-ны өдөр байгуулсан. Нийслэлийн ерөнхий архитекторын 2022.03.04-ний өдрийн МЗХ2022/02-005 дугаартай төслийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Төслийг эхлүүлэх судалгааны ажлыг 2022 оны 4-р сард гүйцэтгэж, Төслийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, ТУХ-г байгуулсан. БНСУ-ын төслийн менежментийн зөвлөх (PMC) багтай хамтран 2022 оны 6-р сард Сайншанд, Зүүнбаян, Хулангын Шанд, Сүхбаатар, Төмөртэй, Хандгайт өртөө, ХНН "УБТЗ"-ын дохиолол холбооны II анги, УБ II өртөөнд ажиллаж RFID (радио давтамжаар тодорхойлох), CCTV (камер) систем суурилуулах байршлын судалгааг гүйцэтгэсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022.08.30-ны өдөр ГТХЗНТ-ийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний 571,626,000 төгрөгийн тендер зарлаж "Эм Эс Эл" ХХК шалгарч 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Төслийн барилгын зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-д 2022.11.17-ны 463 дугаартай албан бичгээр хүргүүлж батлуулсан. БГД-ийн XX хороо "Хөсөг трейд" ХХК-ийн урд замаас ТЗХНУТ-ийн барилга хүртэлх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, төсөвт өртгийн тооцооны төслийг "ЗТХТ" ТӨҮГ гүйцэтгэсэн. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын эх загвар зургийг Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар 2023.04.14-ний өдөр баталсан. Барилгын ажлын зургийг экспертизээр оруулан батлуулахаар зургийн гүйцэтгэгч "Эм Эс Эл" ажиллаж байна. Гадна шугам сүлжээний зураг төсвийг барилгын зураг төслийн ажил гүйцэтгэгчээр хийлгүүлж, авто зам болон гэрэлтүүлгийн зураг төсвийг "ЗТХТ" ТӨҮГ-аар магадлуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ЗТХ-ийн сайдад 2023.04.28-ны өдрийн 183 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. БНСУ-ын Төслийн менежментийн зөвлөх баг, "ГТХЗНТ" УТҮГ хамтран "Төмөр замын аюулгүй байдлын туршилтын системийн үндсэн дизайн" болон одоо байгаа төмөр замын хурдыг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар хэлэлцүүлэгийг 2023.06.27-ны өдөр, төслийн мастер төлөвлөгөөний дундын тайланг танилцуулах арга хэмжээг 2023.06.28-ны өдөр зохион байгуулж Койка, "МТЗ" ТӨХК, "УБТЗ" ХНН, "ТТЗ" ХХК, "МТЛ" ХХК, "Монголиан транс ложистик" ХХК оролцсон. Төслийн менежментийн зөвлөх /PMC/ ирүүлсэн албан бичгийн дагуу "УБТЗ" ХНН-ийн гол шугам замын тээх нэвтрүүлэх чадварыг сайжруулах судалгаа хийх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хэсэглэлийг тодруулахаар албан бичиг хүргүүлээд байна. Төслийн менежментийн зөвлөх /PMC/-ийн мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хийсэн төслийн дундын тайлантай ЗТХЯ, ГТХЗНТ-ийн албаны хүмүүс танилцан холбогдох саналыг 08 сарын 31-ны өдрийн №370 тоот албан бичгээр төслийн менежментийн зөвлөхөд хүргүүлсэн. |
| 2 | 2020 оны А/160 дугаар Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай | 1. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг 2021.01.01-ний өдрөөс тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг харьяа газар, байгууллагуудын дарга, захирал нарт | Төвийн 26 ажилтныг тоон гарын үсгийн токен төхөөрөмжөөр хангасан, тоон гарын үсгийн чиг үүргийг холбогдох ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусган баталсан, албан хэрэг хөтлөлтөд цахим болон тоон гарын үсгийг ашиглаж байна. Төвийн захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар шинээр баталсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх, баримт бичгийг цахимаар солилцох заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. "ГТХЗНТ" УТҮГ-ын 2022 оны цахим шилжилтийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөнд цахим гарын үсгийг хэрэглээг нэмэгдүүлэх хэвшүүлэх зорилтыг тусган батлуулсан. 2022.06.30-2022.09.12-ны өдрийн хугацаанд токен төхөөрөмж ашиглаж тоон болон цахим гарын үсгээр 102 баримт бичгийг төлөвлөж шилжүүлсэн байна. Төвийн ажилтнуудын албан тушаалын нэрс өөрчлөгдсөн тул 2022.08.26-ны өдөр 345 дугаартай албан бичгээр "Үндэсний дата төв"-д хүсэлт гарган өөрчлөлт орсон ажилтнуудын тоон гарын үсгийн гэрчилгээг шинэчлүүлсэн. 2022.09.13-2022.12.02-ны өдрийн хугацаанд тоон болон цахим гарын үсгээр 97 баримт бичгийг төлөвлөж шилжүүлсэн байна. 2023.09.12-ны өдрийн байдлаар тоон болон цахим гарын үсгээр 482 баримт бичгийг төлөвлөж шилжүүлсэн. DOCX албан бичиг солилцооны дундын систем ашигладаг байгууллагуудтай албан бичгээр харилцах зорилгоор тус системд байгууллагын хэрэглэгч ажилтнаар бүртгүүлж, шинээр DOCX токен үүсгүүлж Эйбл системд холбосон. |
| 3 | 2022.03.09 №А/50 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай | 1.2 Зам, тээврийн салбараас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг хөнгөвчилж "И-Монголиа" цахим үйлчилгээний нэгдсэн порталд нэвтрүүлэх | Өмчлөгчийн код болон хөдлөх бүрэлдэхүүний дугаар авах үйлчилгээг И-Монголиа системд нэвтрүүлэх эрэлт хэрэгцээ, технологийн боломж нөхцөлийн талаар цахим хөгжил, харилцаа холбооны яам "И-Монгол Академи"-ийн Төслийн менежер, систем хөгжүүлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Мягмарсүрэн, холбогдох мэргэжилтэнтэй уулзалт хийж санал солилцсон. И-Монголиа төрийн цахим үйлчилгээний системд үйлчилгээг бүртгүүлэх нь одоогоор шаардлагагүй ба зам тээврийн салбарын нэгдсэн платформд хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн модуль хөгжүүлэлтийн ажлыг харгалзан үзэж, цаашид иргэдэд хэрхэн үйлчлэх талаар судласны үндсэн дээр нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн өгсөн санал зөвлөмжийн дагуу зам тээврийн салбарын нэгдсэн платформ дээр үүсгэсэн бүртгэлийн модулийг хөдлөх бүрэлдэхүүний дугаар бүртгэлийн цахим систем байдлаар хөгжүүлсэний дараа нь И-Монголиа төрийн үйлчилгээний системтэй |

| | | | |
|---|---|---|---|
| | | | холбож ашиглахаар төлөвлөөд байна. Салбарын нэгдсэн платформыг олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд ГТХЗНТ-өөс оруулж байгаа хөдлөх бүрэлдэхүүн, гол болон салбар замын бүртгэлд тус бүрийн өгөгдлийг тухай бүр оруулах баяжуулах ажлыг гүйцэтгэж байна.<br>Гэрчилгээ олгогдсон дагнасан хэрэглээний 388 салбар зам, 12501 хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийг СНП-д байршуулсан. Ачаа тээврийн статистик мэдээ (маягт №9б)-ний бүтэц үүсгэн суурь бүтэц эзэмшигч компаниудад мэдээллээ оруулах боломжтой болгосон. Төвийн холбогдох мэргэжилтэн 2023.09.07-08-ны өдөр ЗТХЯ дээр ажиллаж СНП дээрх төмөр замын тээврийн статистик үзүүлэлтүүдийн чарт, дашбоардуудыг цэгцлэх, нэг ижил загвараар дүрслэн харуулах ажлыг гүйцэтгэж байна. |

<u>3.4. Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврын хэрэгжилт:</u>

| Албан даалгаврын тоо | Нийт заалт | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Үнэлгээ өгөөгүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| №01 | 13 | 2 | 9 | - | - | - | 2 | 75.45 |
| №02 | - | - | - | - | - | - | - | - |
| №04 | 19 | 4 | 7 | 1 | - | 2 | 5 | 76.66 |
| **Дүн** | **32** | **6** | **16** | **1** | **-** | **2** | **7** | **76.08** |

“Хэрэгжилт хангалтгүй” 30%-ийн хэрэгжилттэй 1 заалт:

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Хэрэгжүүлэх заалт | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | 2023.05.01-ний өдрийн "Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар | 1.2.Зам, тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулж, хамтран ажиллах | Зам, тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн 2019.05.04-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар Төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг, 5 дугаар хавсралтаар дэд салбар зөвлөлийн дүрмийг баталсан. ГТХЗНТ-ийн төлөөлөл төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтсан. |

<u>3.5.Сайдын шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт:</u>

| Сайдын шуурхай хуралдааны тоо | Үүрэг даалгаврын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Үнэлгээ өгөөгүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | |
| 18 | 76 | 53 | 3 | 1 | - | 8 | 11 | 97.19 |

“Хэрэгжилт хангалтгүй” 1 үүрэг даалгавар:

| № | Огноо, дугаар | Үүрэг даалгавар | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | 2023.01.09 | Салбарын албан хаагчдын орон сууцны | Барилгын архитектур төлөвлөлтийн |

| | | | |
|---|---|---|---|
| | №01 | барилгыг 2023 оны 10 дугаар сард багтаан ашиглалтад оруулах барилга угсралтын ажлын төлөвлөгөө, гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулж 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн нарийн бичгийн даргаар батлуулах. | даалгаврыг өөрчлөн батлуулах асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн 2023.01.05-ны өдрийн хурлаар хэлэлцэж дэмжсэн. Барилгын ажлын төлөвлөгөөг ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулахаар ДАУЗТХ-ийн даргад 2023.01.26-ны өдөр хүргүүлсэн. ЗТХЯ-наас барилгын ажлын төлөвлөгөөг хянан нэмэлт санал өгснийг төлөвлөгөөнд тусгаж Төрийн нарийн бичгийн даргаар 2023.02.17-ны өдөр батлуулсан. |

3.6.Захирлын тушаалын хэрэгжилт:

| Тушаалын тоо | Заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Үнэлгээ өгөөгүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 30 | 0 | | | | |
| 39 | 65 | 34 | 15 | 2 | 6 | 3 | 3 | 2 | 78.52 |

“Хэрэгжээгүй” 0%-ийн хэрэгжилттэй 6 заалт:

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Хэрэгжүүлэх заалт |
|---|---|---|
| 1 | 2023.01.02 Дугаар А/01 Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил болгон зарлах тухай | 2.2/төмөр замын инженер-ирээдүй дурсгалын хөшөө байгуулах; |
| | | 2.3/10 жилийн ойн нэрэмжит галт тэрэг аялуулах; |
| | | 2.7/суурь бүтэц эзэмшигчийн сэлгээний зүтгүүрт FMB640 маркийн төхөөрөмж суурилуулж туршилт зохион байгуулах, үр дүнг танилцуулах; |
| 2 | 2023.01.17 Дугаар А/05 Албан тушаалын тодорхойлолтод нэмэлт оруулах тухай | 2.Албан тушаалын тодорхойлолтод орсон нэмэлтийг нийт ажилтанд танилцуулахыг хүний нөөцийн мэргэжилтэн (М.Оюун-Ундрам)-д үүрэг болгосугай. |
| 3 | 2023.02.16 Дугаар А/13 Төлөвлөгөө батлах тухай | 4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга (М.Оюун-Ундрам)-д даалгасугай. |
| 4 | 2023.07.04 Дугаар А/35 Албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст даалгасугай. |

“Хэрэгжилт хангалтгүй” 30%-ийн хэрэгжилттэй 2 заалт:

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Хэрэгжүүлэх заалт |
|---|---|---|
| 1 | 2023.01.02 Дугаар А/01 Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил болгон зарлах тухай | 2.“Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан төвийн 2023 оны гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийт ажилтанд даалгасугай:<br>2.1/төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын ажлын зураг болон барилга угсралтын ажлын даалгавар боловсруулж батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, төслийн барилгын ажлыг эхлүүлэх; |
| 2 | 2023.07.20 Дугаар А/36 Хариуцлагатай жижүүр томилох тухай | 3.Хариуцлагатай жижүүр ажиллуулсан тухай тайланг 2023.08.25-ны өдрийн дотор нэгтгэж Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст тус тус үүрэг болгосугай. |

3.7.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

| Нэгжийн нэр | Нийт арга хэмжээ | Үнээс | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| ЗСХ | 48 | 20 | 4 | 13 | 4 | 1 | 5 | 1 | 74.59 |

Биелэлт хангалтгүй 0, 30, 50%-иар үнэлэгдсэн 10 арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

“Үр дүнгүй” буюу 0%-ийн үнэлгээтэй 5 арга хэмжээ:

| № | Арга хэмжээ | Хүрэх түвшин |
|---|---|---|
| 1 | Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг шинэчлэн боловсруулах | ***II улирал:***<br>БНШК-ын дүрэм батлагдсан байна. |
| 2 | Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж үр дүнг мэдээлэх | ***Хагас жилийн байдлаар:***<br>Шалгалтыг 1 удаа зохион байгуулж үр дүнг танилцуулсан байна. |
| 3 | Захирлын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах, тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтлөх, нэгж ажилтанд шуурхай хүргэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | ***Хагас жил, жилийн эцсийн байдлаар:***<br>Тогтмол хугацаанд /21-ээс доошгүй удаа/ зохион байгуулж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал болон шуурхайн үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, бусад цаг үеийн асуудлыг хэлэлцэж, явцын мэдээллийг сонсож, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажилласан байна. |
| 4 | Багийн хурлыг зохион байгуулах, тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтлөх, нэгж ажилтанд шуурхай хүргэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | ***Хагас жил, жилийн эцсийн байдлаар:***<br>21-ээс доошгүй удаа зохион байгуулж тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтөлж, нэгж ажилтанд шуурхай хүргэж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажилласан байна. |
| 5 | ЗТХЯ, “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН-ийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлын явцад хяналт тавьж ажиллах | ***I-II улирал:***<br>Архитектур төлөвлөлтийн даалгаварт өөрчлөлт оруулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласан байна.<br>Орон сууцжуулах болон орон сууц захиалан бариулах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн байна. |

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

| № | Арга хэмжээ | Хүрэх түвшин |
|---|---|---|
| 1 | Захирлын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангаж ажиллах | ***Улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар:***<br>- Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх болон танилцуулах асуудлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулсан байна.<br>- Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажилласан байна. |

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50%-иар үнэлэгдсэн 4 арга хэмжээ:

| № | Арга хэмжээ | Хүрэх түвшин |
|---|---|---|
| 1 | Баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах | ***Долоо хоног бүр:***<br>- Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээ болон хариу ирээгүй баримт бичгийн мэдээ гаргаж танилцуулсан байна.<br>***Сар бүр:*** |

| | | |
|---|---|---|
| | | - Төвийн хэмжээнд баримт бичгийг хянан шийдвэрлэсэн тухай мэдээ тайлан гаргаж танилцуулсан байна.<br>***Улирал бүр:***<br>- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргаж танилцуулсан байна.<br>- Хариутай албан бичиг, өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг цахим хуудсанд байршуулж мэдээлсэн байна. |
| 2 | Тэмдэг, хэвлэмэл хуудсын хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллах | ***Хагас жилийн байдлаар:***<br>- Хэвлэмэл хуудсын бүртгэл, зарцуулалтын мэдээ тайлан 1 удаа гарсан байна. |
| 3 | Архивын тооллого, бүртгэлийн ажлыг зохион байгуулах | ***II-III улирал:***<br>Архивын баримтад тооллого зохион байгуулж, тоо бүртгэл хөтөлж, эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлж тайланг танилцуулсан байна. |
| 4 | Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийг үргэлжүүлэх | ***III улирал:***<br>Барилга угсралтын ажлын даалгавар боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. |

3.8.Нэгжийн сарын төлөвлөгөөний хэрэгжилт:

| Сар | Төлөвлөсөн ажил | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | | | | Үнэлгээ өгөөгүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | Хугацаа болоогүй | | |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | | | | | | | | | | |
| I | 16 | 9 | 2 | 1 | 1 | 2 | 1 | - | - | 78.75 |
| II | 14 | 9 | - | 3 | 1 | 1 | - | - | - | 85.00 |
| III | 21 | 11 | 4 | 1 | 2 | 1 | 2 | - | - | 79.05 |
| IV | 16 | 12 | - | - | 3 | - | 1 | - | - | 84.38 |
| V | 16 | 11 | - | 2 | 2 | - | - | - | 1 | 83.75 |
| VI | 19 | 15 | 1 | 1 | 1 | 1 | - | - | - | 91.58 |
| VII | 8 | 8 | - | - | - | - | - | - | - | 100 |
| VIII | *Төлөвлөгөө байхгүй* | | | | | | | | | |
| **Дүн** | **110** | **75** | **7** | **8** | **10** | **5** | **4** | **-** | **1** | **84.90** |
| Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс | | | | | | | | | | |
| I | 13 | 12 | - | 1 | - | - | - | - | - | 97.69 |
| II | 10 | 9 | - | - | - | 1 | - | - | - | 93.00 |
| III | 14 | 12 | - | - | - | 2 | - | - | - | 90.00 |
| IV | 15 | 11 | - | 1 | 1 | 1 | 1 | - | - | 83.33 |
| V | 17 | 12 | - | 4 | - | 1 | - | - | - | 88.23 |
| VI | 13 | 6 | 1 | 1 | - | 1 | - | - | 4 | 87.78 |
| VII | 14 | 11 | - | 2 | - | 1 | - | - | - | 90.71 |
| VIII | 11 | 9 | - | - | - | - | 2 | - | - | 81.81 |
| **Дүн** | **107** | **82** | **1** | **9** | **1** | **7** | **3** | **-** | **4** | **89.09** |
| Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс | | | | | | | | | | |
| I | 8 | 7 | - | - | - | - | - | 1 | - | 100 |
| II | 11 | 9 | - | 2 | - | - | - | - | - | 94.54 |
| III | 11 | 11 | - | - | - | - | - | - | - | 100 |
| IV | 8 | 8 | - | - | - | - | - | - | - | 100 |
| V | 9 | 9 | - | - | - | - | - | - | - | 100 |
| VI | 8 | 8 | - | - | - | - | - | - | - | 100 |
| VII | 5 | 5 | - | - | - | - | - | - | - | 100 |
| VIII | 8 | 8 | - | - | - | - | - | - | - | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **68** | **65** | **-** | **2** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **99.10** |
| **Нийт дүн** | **285** | **222** | **8** | **19** | **11** | **12** | **7** | **1** | **5** | **89.82** |

3.9.Захирлын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

| Хуралдсан огноо | Нийт | Ажилтны нэр | Хэрэгжилтийн хувь | | | | Хугацаа болоогүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | | |
| 2023.01.10 | 10 | М.Оюун-Ундрам | 1 | - | - | 1 | - | 50 |
| | | Д.Бат-Оргил | 1 | | | | | 100 |
| | | У.Уранчимэг | - | - | - | 2 | - | 0 |
| | | Г.Баттөр | - | - | - | 1 | - | 0 |
| | | Нийт ажилтан | - | - | 1 | - | - | 30 |
| | | Д.Амарзаяа, Г.Баттөр | - | 1 | - | - | - | 70 |
| | | Г.Байгалмаа | - | - | - | 2 | - | 0 |
| 2023.03.28 | - | - | - | - | - | - | - | - |
| 2023.06.05 | 7 | Э.Осоржамаа | 1 | - | - | - | - | 100 |
| | | М.Оюун-Ундрам | 2 | - | - | - | - | 100 |
| | | М.Оюун-Ундрам, З.Мөнхтуяа, Б.Буманцэцэг | 1 | - | - | - | - | 100 |
| | | З.Мөнхтуяа | 1 | - | - | - | - | 100 |
| | | Г.Баттөр | 1 | - | - | - | - | 100 |
| | | Д.Амарзаяа | 1 | - | - | - | - | 100 |
| **Дүн** | | | **9** | **1** | **1** | **6** | **-** | **58.82** |

“Үр дүнгүй” буюу 0-30%-ийн үнэлгээтэй 7 үүрэг даалгавар:

| № | Үүрэг даалгавар |
|---|---|
| 1 | Төмөр замын тээврийн салбарын галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны виртуал /симулятор/ орчины сургалтын танхим байгуулах талаар судалгаа хийж, танилцуулга бэлтгэх |
| 2 | Төмөр замын тээврийн акт, гомдол гаргах, шийдвэрлүүлэх үйл ажиллагааны талаар судалгаа хийх, танилцуулга бэлтгэх |
| 3 | Төмөр замын салбарт цахим технологи нэвтрүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны байгууллагын талаар судалгаа хийх, материал цуглуулах |
| 4 | Байгууллагын удирдах ажилтан, албан хаагчдад тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашиглах, нэвтрүүлэх |
| 5 | Байгууллагын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангаж, галын аюулгүй байдлын талаар сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулах |
| 6 | Хэвлэмэл хуудсын бүртгэл, зарцуулалтын мэдээг тогтмол хөтлөх |
| 7 | Багийн хурал зохион байгуулах, хуваарь гаргах, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах |

3.10.Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

| д/д | Шалгуур үзүүлэлтийн төрөл | Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо | Үнэлгээ /хувиар/ | | | | | Хэрэгжилтийн дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 1 | 8.2. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын | 24 | 22 | - | - | 2 | - | 91.66 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | | | | |
| 2 | 8.3 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 7 | 7 | - | - | - | - | 100 |
| 3 | 8.4 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 20 | 9 | - | - | 6 | 5 | 60.0 |
| 4 | 8.5 Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал | 10 | 10 | - | - | - | - | 100 |
| 5 | 8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 4 | 4 | - | - | - | - | 100 |
| **Дүн** | | **65** | **52** | **-** | **-** | **8** | **5** | **86.66** |

3.11.Шилэн дансны хөтлөлт:

| Нэр, төрөл | Тоо | Оруулах мэдээллийн тоо | Баталгаажсан мэдээлэл | Хугацаа хоцроосон мэдээлэл | Мэдээлэл оруулах хугацаа болсон | Мэдээлэл оруулах хугацаа болоогүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Тухай бүр оруулах | 2 | 18 | 18 | - | - | - | 100 |
| Сар бүр оруулах | 3 | 24 | 24 | - | - | - | 100 |
| Хагас жилээр оруулах | 4 | 4 | 4 | - | - | - | 100 |
| Бүтэн жилээр оруулах | 7 | 7 | 2 | - | - | 5 | 100 |
| | **16** | **53** | **48** | **-** | **-** | **5** | **100** |

3.12.Туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилт:

| № | Төлөвлөгөөний нэр | Нийт ажлын тоо | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | ХБ | ҮӨ | |
| 1 | ХАБЭА-н хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны | 16 | 10 | - | - | - | - | 6 | - | - | 62.50 |
| 2 | Гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын | 8 | 5 | - | - | - | 3 | - | - | - | 73.75 |
| 3 | Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх болон танилцуулах асуудлын | 6 | - | - | - | - | - | 6 | - | - | 0.00 |
| 4 | Ажилтанд мэдлэг олгох, бататгах сургалтын | 15 | 5 | - | - | - | - | 5 | 5 | - | 50.00 |
| 5 | ХАБЭА-н сарын аяны | 8 | 6 | - | - | - | - | 2 | - | - | 75.00 |
| 6 | Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сар аяны | 4 | 4 | - | - | - | - | - | - | - | 100 |
| 7 | Бүрэн цахимжсан, | 23 | 14 | 2 | 4 | 2 | - | 1 | - | - | 85.22 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил болгон зарлах тухай 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын | | | | | | | | | | |
| 8 | Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын | 7 | 5 | - | - | - | - | - | 2 | - | 100 |
| 9 | Хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 24 | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | “Монголд зочлох жил”-ийн хүрээнд зам, тээврийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын | 10 | - | - | - | - | - | - | - | - | - |
| 11 | Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын | 13 | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | | **87** | **49** | **2** | **4** | **2** | **3** | **20** | **7** | **-** | **69.37** |

**Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн:**

| № | Баримт бичиг | Нийт арга хэмжээ | Хэрэгжилтийн түвшин /хувиар/ | | | | | | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | Үнэлгээ өгөөгүй | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | | | |
| 1 | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 38 | 21 | 1 | 8 | 5 | - | 2 | 1 | - | - | 81.55 |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | 30.00 |
| 3 | Сайдын тушаал | 22 | 14 | - | 4 | - | 3 | - | 1 | - | - | 84.38 |
| 4 | Сайдын албан даалгавар | 32 | 6 | - | 16 | - | 1 | - | 2 | - | 7 | 76.08 |
| 5 | Сайдын шуурхай хуралдаан | 76 | 53 | - | 3 | - | 1 | - | 8 | - | 11 | 97.19 |
| 6 | Захирлын тушаал | 65 | 34 | - | 15 | - | 2 | 6 | 3 | 3 | 2 | 78.50 |
| 7 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө | 48 | 20 | 4 | 13 | 4 | 1 | 5 | 1 | - | - | 74.59 |
| 8 | Нэгжийн сарын төлөвлөгөө | 285 | 222 | 8 | 19 | 11 | 12 | 7 | 1 | - | 5 | 89.82 |
| 9 | Захирлын шуурхай | 17 | 9 | - | 1 | - | 1 | 6 | - | - | - | 58.82 |
| 10 | Нийтийн мэдээллийн ил тод байдал | 65 | 52 | - | - | - | - | 8 | 5 | - | - | 86.66 |
| 11 | Шилэн дансны хөтлөлт | 53 | 48 | - | - | - | - | - | 5 | - | - | 100 |
| 12 | Туслах чанараар баталсан төлөвлөгөө | 87 | 49 | 2 | 4 | 2 | 3 | 20 | 7 | - | - | 69.37 |
| **Нийт дүн** | | **789** | **528** | **15** | **83** | **22** | **25** | **54** | **34** | **3** | **25** | **84.87** |

## Тав. Дүгнэлт

1.“ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний 38, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 1, сайдын тушаалын 22, сайдын албан даалгаврын 32, сайдын шуурхай хуралдааны 76, захирлын тушаалын 65, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 48, нэгжүүдийн сарын төлөвлөгөөний 285, захирлын шуурхай зөвлөгөөний 17, нийтийн мэдээллийн ил тод байдлын 65, шилэн дансны 53, туслах чанараар баталсан төлөвлөгөөний 87, нийт **789** арга хэмжээг хамруулж хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

2.Хяналт-шинжилгээнд хамрагдсан арга хэмжээнээс биелсэн 543, хэрэгжих шатанд 105, хэрэгжилт хангалтгүй 25, хэрэгжээгүй 54, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 34, хүчингүй болсон 3, үнэлгээ өгөөгүй 25 арга хэмжээтэй, төвийн үйл ажиллагаа 2023.09.27-ны өдрийн байдлаар **84.87**%-ийн биелэлттэй байна.

3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний 3-р улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -1.8%-иар буурсан, тайлан оны 2-р улиралтай харьцуулахад +2.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

4.Хяналтад авсан нийт арга хэмжээний 68.82% нь биелсэн, 13.30% нь хэрэгжих шатанд, 3.16% нь хэрэгжилт хангалтгүй, 6.84% нь хэрэгжээгүй, 4.30% нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 0.38% нь хүчингүй болсон, 3.16%-ийг үнэлгээ өгөөгүй арга хэмжээ эзэлж байна.

5.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +6.15%-иар өссөн, тайлант оны өмнөх улирлаас -0.08%-иар буурсан үзүүлэлттэй байна.

6.Сайдын тушаалын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -9.9%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад -4.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

7.Сайдын албан даалгавруудын хэрэгжилтийг тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +14.51%-иар өссөн үзүүлэлттэй байна.

8.Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +7.19%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +1.25%-иар өссөн үзүүлэлттэй байна.

9. Захирлын тушаалын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -0.98%-иар буурсан, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +5.66%-иар өссөн үзүүлэлттэй байна.

10. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -6.6%-иар буурсан, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +0.96%-иар өссөн үзүүлэлттэй байна.

11. Нэгжүүдийн сарын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +2.02%-иар, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +1.18%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

12. Захирлын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад -21.18%-иар буурсан, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +1.76%-иар өссөн үзүүлэлттэй байна.

13. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад +2.6%-иар өссөн, тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад -10%-иар буурсан үзүүлэлттэй байна.

14. Төвийн үйл ажиллагаанд туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлант оны өмнөх улиралтай харьцуулахад +1.22%-иар өссөн үзүүлэлттэй байна.

## Зургаа. Санал зөвлөмж

“ГТХЗНТ” УТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, анхаарч ажиллах асуудлын талаар дараах санал зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.5, 8.2 дахь арга хэмжээний хэрэгжилт тасарсан буюу 0 үнэлгээтэй байгаад хариуцсан ажилтнууд дүгнэлт хийж ажиллах. “2.5.Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтыг автоматжуулах туршилт судалгаа хийх” арга хэмжээний хүрээнд “УБТЗ” ХНН, “Гайхам” ХХК хамтран сэлгээний зүтгүүрт GPS систем, түлш мэдрэгч системийг байршуулж туршиж байгаа өгөгдлийг хуваалцах, хамтран дүн шинжилгээ хийх ажлыг тууштай хөөцөлдөж тухайн ажлын хэрэгжилтийг ахиулах;

2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4, 1.7, 2.1, 2.2, 2.4, 3.4, 6.4, 6.5, 6.7, 8.4, 8.6, 8.8, 8.9 гэсэн 13 арга хэмжээ 50-70%-ийн үнэлгээтэй байна. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж III болон IV улиралд төлөвлөсөн “зорилтот түвшин”-д бүрэн хүргэх. Тухайлбал:

- 1.4.Эзэмшлийн болон түрээсийн вагон ашиглалтыг сайжруулах, суурь бүтэц хоорондын гэрээний биелэлтийг хангах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах (*Дотооддоо ажлын хэсэг байгуулж, ажилтнуудад холбогдох чиг үүргийг хариуцуулах*)

- 1.7. ОХУ, БНХАУ, Монгол улсын төмөр замын байгууллагуудын зөвлөгөөнд оролцох (*Хуваарь төлөвлөгөө харах, ЗТХЯ-нд оролцох хүсэлт хүргүүлж шийдвэрлэх*)

- 2.1.Барилга угсралтын ажлын даалгавар боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

- 2.2. КОЙКА-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон төслийн менежментийн зөвлөх багт Монгол талын ажлын даалгаврыг танилцуулж төслийн мастер төлөвлөгөөнд тусгуулах

- 2.4.Чичиргээний зонхилох давтамжийг тодорхойлох туршилтын үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, судалгааны дүгнэлтийг төмөр замын байгууллага, ЗТХЯ-нд танилцуулах (*МТЗ-тай хамтран мидлинг тээврийн хөдлөх бүрэлдэхүүнд хийх туршилтын ажлын үр дүнг МТЗ-д, 2 удаагийн туршилтын үр дүн, судалгааны дүгнэлтийг ЗТХЯ-нд танилцуулах*)

- 3.4.Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн боловсруулж Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийн дагуу төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх (*Журмыг шинэчлэн боловсруулж дуусгах, харилцан мэдээлэл солилцох жагсаалт болон хавсралт маягтуудыг шинэчлэх, сайдын 93 дугаар тушаалтай харьцуулж давхардал, хийдлийг арилгах, СНП дээрх төмөр замын тээврийн статистик мэдээний бүтэц агуулгатай ижилсүүлэх, энэ ажлыг эзэн биежүүлэх, холбогдох ажилтанд хариуцуулах*)

- 6.4.Төмөр замын туннелийн зураг төсөл зохиох стандарт стандартыг орчуулж боловсруулах

- 6.5.Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт MNS 6630:2016 стандартыг ТЗДАУЗТС-ын Техникийн хороогоор хэлэлцүүлэх

- 6.7.Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмыг шинэчлэн боловсруулж Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийн дагуу төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх (*Цахим системийг нэвтрүүлснээр гарч буй дэвшилттэй болон дутагдалтай талуудад дүн шинжилгээ хийж, бүрдүүлэх баримт бичиг, тавигдах шаардлагыг өөрчлөх үр дүнтэй саналыг ЗТХ-ийн сайдын тушаалаар батлагдсан дэд ажлын хэсэгт хүргүүлж тусгуулах*)

- 8.4.Сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврыг мэдээлэх, биелэлтийг тайлагнах, үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэх

- 8.6.Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулах, архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлэх, тооллого зохион байгуулж дүн мэдээ гаргах (2022 оны ХХНЖ-д тусгагдсан санхүүгийн баримтыг архивт бүрэн бүрдэлтэйгээр авах, архивын баримт бичгийн тооллого хийх)

- 8.8.Албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн батлуулах, ҮОХХМШӨ-өөс урьдчилан сэргийлэх болон гамшгаас хамгаалах сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах

- 8.9. Жендэрийн эрх тэгш байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон Авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, Хэрэглээний хууль тогтоомжийн эрх зүйн мэдлэг олгох, бататгах сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мэдлэг, ойлголтыг бататгах шалгалт зохион байгуулж үр дүнг мэдээлэх

3.Түүнчлэн 100%-иар үнэлэгдсэн хэдий ч IV улирал болон жилийн эцсийн байдлаар тодорхой ажил зохион байгуулан хэрэгжүүлж биелэх “зорилтот түвшин”-тэй 1.1. өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг баталж мөрдүүлэх, 1.2. зуны цагийн хуваарийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах албан даалгаврын биелэлтийг хангуулах, 1.3. зурмагийн дүнгийн хурал зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцох, 7.2. бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр шинээр 100 мод, бут, сөөг тарих арга хэмжээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, бүрэн хэрэгжүүлэх;

4.Хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй, бүрэн биелээгүй бусад заалт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар нийт ажилтны хурал, захирлын шуурхай зөвлөгөөн, нэгжийн хурлыг зохион байгуулж удирдлагаас тодорхой чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

5. Ажил цалгардуулж, удаашруулсан, үүрэг даалгавар биелүүлээгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, үйл ажиллагаа болон хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлээгүй, мөрдөөгүй, дотоод журам зөрчсөн ажилтанд хуульд зааснаар сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлж тухай бүр хариуцлага тооцож ажиллах.

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА Ц.ОЮУНБАТ

ТНУАСХ-ИЙН ДАҮТОГ Б.БУМАНЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗСХ-ИЙН ХШҮМ Э.ОСОРЖАМАА